МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ “УВДИСЫН ДАЛАЙ” ЭХ ЗОХИОЛ ДАХЬ ХҮДРИЙН ЗААР АГУУЛСАН ЭМҮҮДЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Т.Халиунаа, Б.Уганбаяр, Ч.Чимэдрагчаа

Уламжлалт Анагаах Ухаан, Технологийн Хүрээлэн
bk_haliuka_mon@yahoo.com

Түлхүүр үг:
Хүдрийн заар, эх сурвалж, уламжлалт жор

Товч утга: Сүүлийн жилүүдэд дэлхий нийтээрээ байгалийн гаралтай эмт бодис, ургамлын эм, бэлдмэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн хэрэглэх нь ихээр нэмэгдэж байгаа бөгөөд ДЭМБ-аас уламжлалт анагаах ухаанд хэрэглэж ирсэн эмт бодис, жоруудыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судалж үйлдвэрлэл, практикт нэвтрүүлэхийг уриалж байгаа билээ. Хүдэр нь Монгол улсаас гадна Вьетнам, Энэтхэг, Хятад, Хойд Солонгос, Өмнөд Солонгос, Орос, Казакстан, Киргизстан зэрэг дэлхийн 14 улсад 6 зүйлийн Хүдэр тархсан байх бөгөөд Монгол оронд Сибирийн хүдэр буюу Баданга хүдэр /Moschus moschiferus Linnaeus/ амьдардаг байна.

“Увдисын далай” эх зохиолд Хүдрийн заар агуулсан нийт 342 жор тэмдэглэгдсэнээс талх эм хамгийн олон буюу 259, үрэл эм 42, гадуур хэрэглэх эм 29, тан эм 7, хандан эм 4, тосон эм 1 байлаа. Мөн Хүдрийн зааpаас гадна түүний хорголыг эмчилгээнд хэрэглэх талаар дурдагдсан байгааг судлан илрүүллээ. Уг зохиолд нийт 29 төрлийн өвчин эмгэгийг анагаах жорын найрлагад Хүдрийн заар орсон байгаа бөгөөд оноож нэрлэсэн 214 жорын найрлагаас нян өвчин, халуун өвчин, нүдний өвчнийг засах жорууд хамгийн их байгаа бол нэргүй 128 жороос нян өвчин, аахар шаахар өвчин, толгойн өвчин, халуун өвчнийг засах жорууд хамгийн их байна.

Үндэслэл: Сүүлийн жилүүдэд дэлхий нийтээрээ уламжлалт анагаах ухаан, түүний дотроос амьтны болон байгалийн гаралтай уламжлалт эмт бодис, ургамлын эм бэлдмэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн хэрэглэх явдал ихээхэн өсөж эрдэмтэн судлаач нар энэ чиглэлд анхаарлаа хандуулах нь нэмэгдсээр байна. Уламжлалт анагаах ухааны жор найрлагад хамгийн их ордог гурван амьтны гаралтай түүхий эдийн нэг нь Хүдрийн заар юм. Судар бичигт шимийн эмийн аймагт Хүдрийн заарыг амьтны гаралтай шимийн эм гэж үздэг байна.[1]

Арабын эмч Serapio нь эр хүдрийнх нь хэвлий орчимд тахианы өндөгний дайтай хоёр бөөрөнхий зүйл байсныг олж тэмдэглэн, түүнээс нэг л сонин үнэртэй шингэн ялгарч байсныг “заар” хэмээн нэрлэсэн түүхтэй ба хүдрийн тухай анх арван нэгдүгээр зуунд тэмдэглэн бичиж үлдээжээ.[2]

Түүнчлэн заарыг Хятад, Солонгосын уламжлалт анагаах ухааны 300-гаад эмийн жорд оруулан тайвшруулах, сэргээх, зүрх судас, мэдрэл, амьсгал янз бүрийн өвчнүүд болон бэлгийн сулралыг эмчлэх, оюун ухааныг сайжруулах зорилгоор хэрэглэдэг (Mills, 1998), төв мэдрэлийн систем болон зүрхний үйл ажиллагааг эрчимжүүлдэг, могойн хорын эсрэг болон үрэвслийн эсрэг идэвхтэй үйлдэлтэйг судлан тогтоосон (Gaski and Johnson, 1994) байна.[3]

Монголын уламжлалт анагаах ухаанд Хүдрийн заарыг тархины судасны бүлэн, тархинд цус харвах, үе мөч бадайрах, хэл яриа саажих, мэдрэхүй алдагдах хам шинж, сарын тэмдгийн хямрал, артерийн даралт ихсэх болон үе мөчний өвчин, неврит зэргийг засахад хэрэглэдэг ба Б.Болдсайхан (2000) нарын судалгаагаар Монголын уламжлалт анагаах ухааны 4000 жороос 573-д нь Хүдрийн заар оржээ.[4]

Зорилго:

Монголын уламжлалт анагаах ухааны нэрт оточ Жамбалчойжиданзанпэрэнлэйн туурвисан “Увдисын далай” эх зохиолд тэмдэглэгдсэн Хүдрийн заар агуулсан жоруудыг агуулга бүтцийн талаар тодруулан судлах

Зорилт:

1. Хүдрийн заарыг уламжлалт эмийн ямар хэлбэрүүдэд хэрэглэгдэж ирснийг тодруулах
2. Хүдрийн заар агуулсан жоруудыг ямар өвчин эмгэгийг анагаахад хэрэглэгдэж байсныг судлан тогтоох

Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн, арга зүй:
Монголын уламжлалт анагаах ухааны эх зохиол болох Жамбалчойжиданзанпэрэнлэйн (1789-1838) туурвисан "Увдисын далай"-г үндсэн хэрэглэгдэхүүн болгож эх бичиг, сурвалж бичиг судлалын аргыг ашиглан эрт үеэс тэмдэглэж үлдээсэн баримт бичгээс тодруулан судалж, шүүн тунгааж үзэх аргуудыг ашигласан. [5,6]

Судалгааны ажлын үр дүн:

1. "Увдисын далай" зохиолд Хүдрийн заарыг агуулсан жорд хийсэн үр дүн:

Амьтдын дотроос эмийн жор найрлагад хамгийн их ордог гурван түүхий эд байдаг бөгөөд түүний нэг нь Хүдрийн заар юм.

Хүснэгт 1. Хүдрийн заар агуулсан уламжлалт эмүүдийн хэлбэрийг тодруулсан дүн

Нэр	Оноож нэрлэсэн жор	Нэргүй жор	Талх эмийн жор	Үрэл эмийн жор	Гадуур хэрэглэх эмийн жор	Тан эмийн жор	Хандан эмийн жор	Тосон эмийн жор
Жорын тоо	214	128	259	42	29	7	4	1

Энэхүү зохиолд Хүдрийн заарыг агуулсан нийт 342 жор тэмдэглэгдсэнээс нэр өгч оноож нэрлэсэн жор 214, нэргүй 128 жор байна. Эдгээрийг эмийн хэлбэрээр ялгавал талх эмийн 259 жор, үрэл эмийн 42 жор, гадуур хэрэглэх эмийн 29 жор, тан эмийн 7 жор, хандан эмийн 4 жор, тосон эмийн жор 1 байна.

Түүнчлэн Хүдрийн зааргаас гадна түүний хорголыг төөнө засалд хэрэглэдэг байсан талаар дурьдсан байна.

2. Хүдрийн заар агуулсан жоруудыг ямар өвчин эмгэгийг анагаахад хэрэглэгдэж байсныг судалсан үр дүн:



Зураг 1. Хүдрийн заар агуулсан оноосон нэртэй уламжлалт эмүүдийн паянг харьцуулсан байдал

Жамбалчойжиданзанпринлэйн "Увдисын далай" эх зохиолоос оноож нэрлэсэн жоруудыг шүүж үзэхэд нийт 214 байсан бөгөөд нян өвчнийг засах 59, халуун өвчнийг засах 25, нүдний өвчнийг засах 15, боомыг засах 12, цайвар хаванг засах 10, бодоо өвчнийг засах 9, бөөрний өвчнийг засах 8, хий өвчин, шарын өвчин, хурмал өвчин, хорхой өвчин, толгойн өвчнийг засах тус бүр 6 жор, дагшуур (томуу)-ыг засах, хөлийн бам өвчин, цанх өвчнийг засах тус бүр 5 жор, дусал цувирахыг засах, тулай өвчнийг засах тус бүр 4 жор, эс шингэсэн өвчин, цагаан судлын өвчин, хэрх өвчнийг засах тус бүр 3 жор, элэгний өвчин, хар судлын өвчин, амны өвчин, хошногоны гөвдрүү, нүдэт ярыг засах тус бүр 2 жор болон уушгины өвчнийг засах, дэлүүний өвчнийг засах, эвэрхий өвчнийг засах, ходоодны өвчнийг засах тус бүр 1 жор найрлагад Хүдрийн заар орсон байна.



Зураг 2. Хүдрийн заар агуулсан оноосон нэргүй бичигдсэн уламжлалт эмүүдийн паянг харьцуулсан байдал

Харин нэргүй эмийн түүхий эдүүдийг бичсэн 128 жор байсан бөгөөд нян өвчнийг засах 27, аахар шаахар өвчнийг засах 25, толгойн өвчин, халуун өвчнийг засах тус бүр 8 жор, бодоо өвчнийг засах 7, амны өвчнийг засах 6, чихний өвчин, нүдний өвчин, хэрх өвчнийг засах тус бүр 5 жор, хоолойн өвчин, цайвар хаванг өвчин, тулай өвчнийг засах тус бүр 3 жор, шарын өвчин, хамрын өвчин, бөөрний өвчин, ходоодны өвчин, хөлийн бам өвчнийг засах тус бүр 2 жор, хурмал өвчин, эс шингэснийг өвчин, эмэгтэйн бэлэгсийн өвчин, боом өвчин, зогисох өвчин, суулгах өвчин, бөөлжих өвчин, шээс хаагдах өвчин, нүдэт яр, гал намсийг засах, сүрьеэ өвчин, уушгины өвчин, гөвдрүүг засах тус бүр 1 жор байна.

Хэлцэмж: Бидний судалгааны үндсэн хэрэглэгдэхүүн болох "Увдисын далай" эх зохиол нь Монголын уламжлалт анагаах ухааны эм найрлага судлалын хамгийн том, иж бүрэн зохиол болно. Тус номонд үндсэн 6 өвчин, халуун өвчин, нян өвчин, таван эрхтний өвчин, цул савын өвчин, аахар шаахар өвчин, гадар яр зэрэг өвчин эмгэгийг анагаах аргыг 112 бүлэгт хуваан үзүүлж, нийт 2528 эм найрлага хураангуйлагдан эмхэтгэгджээ.[7]

Жамбалчойжиданзанпэрэнлэйн (1789-1838) туурвисан "Увдисын далай" эх зохиолд тэмдэглэгдсэн Хүдрийн заар агуулсан жоруудыг тодруулан судаллаа. Уг эх зохиолд тэмдэглэгдсэнээр нийт 29 төрлийн өвчин эмгэгийг анагаах үйлдэлтэй, нийт жорын 342 буюу

13.5 хувь нь Хүдрийн заар агуулсан жор найрлага байлаа. Мөн Хүдрийн заараас гадна түүний хорголыг эмчилгээнд хэрэглэх талаар дурдагдсан байгааг судлан илрүүллээ.

Судлаач Б.Болдсайхан, Ц.Оюунцэцэг (2000) нарын судалгаагаар Монголын уламжлалт анагаах ухааны нийт жорын 14.3 хувь нь Хүдрийн заар агуулсан байдаг болохыг тогтоосон.[8]

"Увдисын далай" зохиолд нян, хижгийн өвчнийг анагаах жор болох Есөн харын найрлагыг утлага, зүүх болон уух гэсэн гурван хэлбэрээр хэрэглэдэг тухай тэмдэглэсэн байна.

Судлаачид сүүлийн үед Хүдрийн заар, түүнийг агуулсан жорууд болох Гарди-5, Сампилноров буюу Эрдэнэ үрэл, Ноцог-6, Гүргэм-13, Манагчэнмо зэрэг Хүдрийн заар агуулсан жоруудыг орчин үеийн судалгааны аргуудаар судлан баталгаажуулж эхлээд байна.

Дүгнэлт:

1. "Увдисын далай" эх зохиолд Хүдрийн заар агуулсан нийт 342 жор тэмдэглэгдсэнээс талх эм хамгийн олон буюу 259, үрэл эм 42, гадуур хэрэглэх эм 29, тан эм 7, хандан эм 4, тосон эм 1 байлаа. Мөн Хүдрийн заараас гадна түүний хорголыг эмчилгээнд хэрэглэх талаар дурдагдсан байгааг судлан илрүүллээ.
2. Уг зохиолд нийт 29 төрлийн өвчин эмгэгийг анагаах жорын найрлагад Хүдрийн заар орсон байгаа бөгөөд оноож нэрлэсэн 214 жорын найрлагаас нян өвчин, халуун өвчин, нүдний өвчнийг засах жорууд хамгийн их байгаа бол нэргүй 128 жороос нян өвчин, аахар шаахар өвчин, толгойн өвчин, халуун өвчнийг засах жорууд хамгийн их байна.

Талархал: Уг судалгааны ажлыг хийж гүйцэтгэх явцад удирдан чиглүүлж эрдэм мэдлэг, оюун ухаан, санал шүүмжээ харамгүй хайрласан АУ-ы доктор Б.Ууганбаяр, УАУТХ-ийн захирал, МАУА-ийн гишүүн, АУ-ы доктор, профессор Ч.Чимэдрагчаа багш нартаа чин сэтгэлээсээ талархал илэрхийлж байна.

Ном зүй:

1. *Цэндийн Хайдав "Бүтээлийн чуулган" I боть ном. Улаанбаатар 2013 он. х.311, 341.*
2. *R.W.Moncrieff. The Chemical Senses, Leonard Hill. London; 1967.*
3. *Gaski AL JK. Prescription for extinction. Econ (United Kingdom). 1994;412.*
4. *Болдсайхан Б, Оюунцэцэг Б. Хүнс Эмийн Язгуур Махбодийн Нэрийн Толь Бичиг. Төвөд-Латин-Монгол-Орос. Согоо нуур ХХК; 2000.*
5. *Ш.Болд. Монголын уламжлалт анагаах ухааны хөгжлийг эх сурвалжийн судалгаагаар тодруулах нь. Анагаахын шинжлэх ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Шинжлэх ухааны академи. УБ. 2005. х.26.*
6. *Charles C. Ragin. The Comparative Method: Moving Beyond Qualitative and Quantitative Strategies. University of California Press, 1987. p.12-16.*
7. *Жамбалчойжиданзанпэрэнлэй. Увдисын Далай.; 2014.*
8. *Болдсайхан Б, Оюунцэцэг Б. Хүнс Эмийн Язгуур Махбодийн Нэрийн Толь Бичиг. Төвөд-Латин-Монгол-Орос. Согоо нуур ХХК; 2000.*

ANALYSIS OF DRUGS CONTAINING NATURAL MUSK IN MONGOLIAN TRADITIONAL MEDICINE'S SOURCEBOOK "UWDISIIN DALAI"

Khaliunaa T, Uuganbayar B, Chimedragchaa Ch

Institute of Traditional Medicine and Technology, Ulaanbaatar, Mongolia
bk_haliuka_mon@yahoo.com

In recent years, the use of natural medicines, herbal medicines, and biologically active products has been increasing worldwide, and the World Health Organization (WHO) is calling for scientific research of drugs, medicinal substances, recipes used in traditional medicine and to implement it for the production and practice.

Six species of musk deer is distributed extensively in 14 countries, such as Mongolia, Vietnam, India, China, South and North Korea, Russia, Kazakhstan, and Kyrgyzstan. The Siberian musk deer (Moschus мoschiferus Linnaeus) lives in Mongolia. A total of 342 recipes containing musk were recorded in the "Uwdisiin dalai" sourcebook, among them the powder medicine recipes of 259 were the most common, 42 recipes for pill medicine, 29 recipes for external medication, 7 recipes for decoction medicine, 4 recipes for extract medicine and 1 medicinal oil. In addition to the musk, we have detected that its dung has been used for the treatment. In the sourcebook, the musk was included in the recipes for the treatment of 29 types of diseases. From the named 214 recipes, the recipe for treating bacterial diseases, heat disease and eye diseases were common, whereas from the unnamed 128 recipes, the recipe for bacterial diseases, diarrhea, headaches and heat diseases were common as well.